



## АУДИТЫН КОД: САГ-2018/14/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я. Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 260512 Цахим хаяг: [khongorzull@audit.gov.mn](mailto:khongorzull@audit.gov.mn)

Аудитор Н.Золзаяа

Утас: 260512 Цахим хаяг: [zolzayan@audit.gov.mn](mailto:zolzayan@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## АГУУЛГА

1	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ .....	2
2	АУДИТЫН ТАЙЛАН .....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.5	Дотоод хяналт .....	6
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	7
2.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд .....	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
2.16	Үр өгөөжийн тооцоолол .....	10
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ .....	11
3.1	Бараа материалын бүртгэлийн талаар .....	12
3.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар .....	13
4	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
5	АКТ, АЛБАН ШААРДЛАГА .....	20

1 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1036  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН  
КОМИССЫН ДАРГА Я.САНЖМЯТАВ  
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.2-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0425SAG26.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга Я.Санжмятав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын бүртгэл хөтлөлтийн онцлогт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, бараа материалыг тооцооны дансаар дамжуулан зөв бүртгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 06-наас 2018 оны 4 дүгээр сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн



аудитын газрын аудитор Н.Золзаяа, гэрээт аудитор С.Оюунтунгалаг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 64 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Улс төрийн хилс хэрэгт баривчлагдсан, мөрдөгдсөн, шийтгүүлсэн бүх иргэдийн хэргийг шалгуулж нотлох эд мөрийн баримтад тулгуурлан тэднийг цагаатгуулах;
- Хэлмэгдсэн иргэдийн нэр төрийг сэргээлгэх;
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн нь нотлогдож улмаар цагаатгагдсан иргэдийн дурсгалыг мөнхжүүлэх;
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөх олговор олгох;
- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршигт үр дагаврыг арилгах бодлого зэрэг болно.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.


Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын комиссын дүрэм, улс төрийн цагаатгалын ажилтай холбогдсон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээж дурсгалыг мөнхжүүлэх, хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, хүүхэд, төрөл төрөгсдөд нийгмийн халамжийн зарим туслалцааг үзүүлэх, улс төрийн хэрэгт баривчлагдсан, мөрдөгдсөн, шийтгүүлсэн иргэдийн шалгагдаагүй үлдсэн хэргүүдийг холбогдох байгууллагуудаар үргэлжлүүлэн шалгуулж, цагаатгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 4 хөтөлбөр, 14 зорилт, 58 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж ажилласан байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Цагаатгах



ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 22 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул өөрийн байгууллагын бүртгэлийн онцлогт тохируулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх шаардлагатай байна гэж үзлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн санхүүгийн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “дунд” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.


Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь бүтэц, орон тооноос шалтгаалан дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд нийт 563.8 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 97.5 хувь буюу 549.7 сая төгрөг ба батлагдсан төсвийг 14.1 сая төгрөгөөр хэмнэжээ.



Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвөөр “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төсвийг баталсан байна. Зардлын зориулалтаар авч үзвэл хэлмэгдэгсдийн ар гэрт олгох тэтгэмж, урамшууллын зардал 70.0 хувь зарцуулагдаж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал тус тус 100.0 хувь, ахмад дайчдад үзүүлэх орон сууцны дэмжлэг 99.0 хувь, Үндсэн үйл ажиллагааны зардал 65.0 хувь зарцуулагдсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр);
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр) зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:





Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь 2017 онд хөрөнгө бэлтгэх батлагдсан төсөвгүй, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр 13.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "... үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1.5 сая төгрөгийн дотоод томилолтын зардлыг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Баримтгүй зарцуулсан 1.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь 8.1 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21-т заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах аудитын зөвлөмж хүргүүлэв.


Батлагдсан төсөв нийт болон бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч байр ашиглалттай холбоотой зардлаас 2.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, цалин хөлсний зардлаас 1.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын шийтгэлийн зардалд, тэтгэмж урамшууллын зардлаас 12.1 сая төгрөгийг цалин хөлсний зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай болон Сангийн сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангилалтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, давхардсан дүнгээр 63.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан болно. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт № 1 Аудитын зөвлөмжөөр санхүүгийн тайланд залруулсан алдааны бүртгэл

		сая.төг
№	Аудитын зөвлөмжөөр санхүүгийн тайланд хийгдсэн залруулгын товч утга	дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогыг дутуу тохируулсан 22.0 сая төгрөгөөр бууруулж залруулсан.	22.0
2	Төсвийн гүйцэтгэлийн зарлагыг дутуу тохируулсан 7.9 сая төгрөгөөр бууруулж залруулсан.	7.9
3	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан дүнгээр ХХОАТ-ын авлагыг 0.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 0.01 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж залруулсан.	0.3
4	Алдаатай бүртгэсэн биет бус хөрөнгийг данснаас хасч залруулсан	3.0
5	Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдлийг томилолтын урьдчилгаа 8.7 сая, програмын үнийн урьдчилгаа 3.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.	11.7



**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн  
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

6	Санхүүгийн үр дүнгийн зардлын дүнг тайлант онд хэрэгжээгүй албан томилолтын зардал 8.7 сая, зардлаар илүү тусгасан нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын 0.6 сая төгрөгөөр тус тус бууруулж залруулсан.	9.3
7	Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийг дутуу тайлагнасан 3.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж илүү тайлагнасан 0.3 сая төгрөгөөр бууруулж залруулсан.	2.8
8	Өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдлийг зардал бууруулсан 9.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, богино хугацаат өр төлбөр дансны өсөлт 2.8 сая төгрөгөөр бууруулж залруулсан.	6.2
<b>Нийт залруулсан алдааны дүн</b>		<b>63.2</b>

Эх сурвалж: Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

### 2.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн зарцуулалт;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон анхан шатны баримтын бүрдүүлэлт;

### 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 102.0 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс нягтлан бодох бүртгэлийн 63.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.5 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоож, 29.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 8.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүллээ.

### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна. Аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнөөс холбогдох байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх зөвлөмж биелээгүй, 2017 оны аудитаар зөрчил давтан гарсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.


Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын 2018 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 123 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

### 2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 529.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 10.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Энэ нь төлөвлөлтийн үед тооцсоноос 0.2 сая төгрөгөөр багассан ба үр дүнгийн тайланд 9.2 сая төгрөгийн залруулга хийгдсэнтэй холбоотой байна.



## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тусвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан болно.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 2.16 Үр өгөөжийн тооцоолол

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 94.0 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитынн горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



**3.1 Бараа материалын бүртгэлийн  
талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт:**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь 8.0 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21-т заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд:**

Төсвийн зарцуулалтанд тавих хяналт алдагдах  
Төсөв үр ашиггүй зарцуулагдах  
Өглөг авлага буруу илэрхийлэгдэх

**Төсвийн захирагчийн хариу:**

Зөвшөөрч хэрэгжүүлнэ.



**3.2 Нягтлан бодох бүртгэлийн  
бодлогын баримт бичгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт:**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүйгээс алдаатай бичилт гарч байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд:**

Нягтлан бодох бүртгэл алдаатай илэрхийлэгдэх

**Төсвийн захирагчийн хариу:**

Зөвшөөрч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### 4 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	14,507.0	35,422.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	0.0
33	АВЛАГА	0.0	285.0
34	УРЬДЧИЛГАА	208.4	14,479.3
35	БАРАА МАТЕРИАЛ	14,298.6	20,657.9
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	35,348.8	37,509.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,348.8	37,509.5
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	29,598.8	33,384.5
39300	Биет бус хөрөнгө	5,750.0	4,125.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	49,855.7	72,931.7
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	70,992.9	3,094.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,992.9	3,094.3
41300	Өглөг	70,992.9	3,094.3
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	-21,137.2	69,837.4
51	Засгийн газрын хувь оролцоо	-21,137.2	69,837.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,239.4	50,239.4
51200	Хуримтлагдсан үр дүн	-72,208.4	18,766.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	831.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	49,855.7	72,931.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код:	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	471,837.4	571,687.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	471,837.4	571,687.5
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	557,475.1	529,043.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,475.1	529,043.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,625.0	287,455.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,327.2	140,878.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,050.9	17,176.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,902.4	27,580.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,615.0	23,741.7
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,375.8	8,304.0
2107	Томилолт, зочны зардал	4,155.4	14,312.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,084.2	25,760.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,114.1	29,700.9
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,850.1	241,588.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-85,637.7	42,643.9
5	НИЙТ ҮР ДҮН	-85,637.7	42,643.9





### 4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧ
3	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	64,500.5	0.0	64,500.5
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,500.5	0.0	64,500.5
9	Тайлант үеийн үр дүн	-85,637.7	0.0	-85,637.7
10	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-21,137.2	0.0	-21,137.2
11	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-21,137.2	0.0	-21,137.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	48,330.7	0.0	48,330.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,193.6	0.0	27,193.6
18	Тайлант үеийн үр дүн	42,643.9	0.0	42,643.9
19	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	69,837.4	0.0	69,837.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	477,625.2	571,687.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	475,132.2	571,687.5
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	474,488.6	561,130.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,488.6	561,130.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	246,343.7	296,905.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,097.8	140,878.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,087.4	15,591.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,902.4	27,580.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,943.4	25,080.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,968.8	8,304.0
2107	Томилолт, зочны зардал	4,506.4	24,135.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,304.2	30,339.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,533.2	24,996.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,144.9	264,224.4
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	3,136.6	10,557.2
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	3,136.6	10,557.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,136.6	10,557.2
2200	Дотоод эх үүсвэрээр	3,136.6	10,557.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-3,136.6	-10,557.2
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-0.1	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.1	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0




#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	563,787,500.00	549,700,153.61	-14,087,346.39	97.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	563,787,500.00	549,700,153.61	-14,087,346.39	97.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,360,500.00	299,563,153.61	-2,797,346.39	99.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,737,200.00	140,878,515.61	-858,684.39	99.39
210101	Үндсэн цалин	109,463,800.00	108,757,125.00	-706,675.00	99.35
210102	Нэмэгдэл	25,157,900.00	25,005,937.30	-151,962.70	99.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,115,500.00	7,115,453.31	-46.69	100.00
210104	Урамшуулал	0.00	0.00	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,591,100.00	15,591,100.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,921,600.00	9,915,939.60	-5,660.40	99.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,417,500.00	701,599.50	-715,900.50	49.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,133,800.00	1,434,381.20	300,581.20	126.51
210204	Ажилгүйдлийн даатгал	283,400.00	701,599.50	418,199.50	247.57
210205	Эрүүл мэндийн даатгал	2,834,800.00	2,837,580.20	2,780.20	100.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,987,100.00	27,580,000.00	-407,100.00	98.55
210304	Байрны түрээс	27,987,100.00	27,580,000.00	-407,100.00	98.55
2104	Хангамж, бараа материалын зардал	21,377,500.00	20,646,493.00	-731,007.00	96.58
210401	Бичиг хэрэг	4,412,600.00	4,405,166.00	-7,434.00	99.83
210402	Тээвэр, шатахуун	6,917,100.00	6,917,100.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,592,500.00	2,905,961.00	-686,539.00	80.89
210404	Ном, хэвлэл	0.00	0.00	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,455,300.00	6,418,266.00	-37,034.00	99.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,316,000.00	8,316,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	8,316,000.00	8,316,000.00	0.00	100.00
2107	Томиллолт, зочны зардал	24,388,400.00	24,135,803.00	-252,597.00	98.96
210702	Дотоод албан томиллолт	24,388,400.00	24,135,803.00	-252,597.00	98.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,920,700.00	37,418,330.00	-502,370.00	98.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,137,700.00	28,849,960.00	-287,740.00	99.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,783,000.00	8,568,370.00	-214,630.00	97.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,042,500.00	24,996,912.00	-45,588.00	99.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,277,000.00	2,231,483.00	-45,517.00	98.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,765,500.00	22,765,429.00	-71.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,427,000.00	250,137,000.00	-11,290,000.00	95.68



Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн  
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	261,427,000.00	250,137,000.00	-11,290,000.00	95.68
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,327,000.00	40,327,000.00	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	217,800,000.00	206,510,000.00	-11,290,000.00	94.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	563,787,500.00	549,700,153.61	-14,087,346.39	97.50
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	563,787,500.00	549,700,153.61	-14,087,346.39	97.50
310001	Улсын төсвөөс санхүүжих	563,787,500.00	549,700,153.61	-14,087,346.39	97.50
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	11.00	0.00	0.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	0.00

